

ТУЗ-ийн 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн
23/001 тоот тогтоолын хавсралт

“МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ” ХХК



FINANCE

ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

2023 он

ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү залгамж халааны бодлого (цаашид "Бодлого" гэх)-ын зорилго нь " МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн эрх бүхий болон түлхүүр албан тушаалтны залгамж халааг урьдчилан бэлтгэх, хөгжүүлэх, сургахад оршино.
- 1.2 Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан гэдэгт Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд Эрх бүхий албан тушаалтнаар тусгагдаагүй боловч бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, компанийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн хэрэгжилтэд чухал ач нөлөө, оролцоотой, компанийг төлөөлж гэрээ хэлцэл байгуулах эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулан ойлгоно.
- 1.3 Компанийн Залгамж халааны бодлогын ач холбогдлыг Компанийн бүх ажилтнуудад сурталчилан таниулахад удирдлагын багийн гишүүд чухал үүрэгтэй оролцоно.

ХОЁР. ЗАЛГАМЖ ХАЛААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид "Хороо" гэх/ байгуулан ажиллана.
- 2.2 Хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ батална.
- 2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтан томилох нэр дэвшигчийг тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.4 Эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх нэр дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хөгжүүлж, үнэлж, дүгнэх замаар бодлогыг хэрэгжүүлнэ,
- 2.5 Хүний нөөцийн менежер нь Гүйцэтгэх захирлын хамтаар ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөө гаргах богоод албан тушаал дэвшин ажиллах боломжтой, чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.6 Бизнесийн хэрэгцээ шаардлагаар газар, нэгж, хэлтсуудийн орон тоог Гүйцэтгэх захирал санал болгож, ТУЗ-ийн шийдвэрээр батална.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхолын зөрчил үүссэн эсэхэд хяналт тавьж дүгнэлт гаргаж ажиллана.
- 3.2 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гарган. ТУЗ-д танилцуулна
- 3.3 Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдлыг тогтоох тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцна.

ДӨРӨВ. ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ

- 4.1 Эрх бүхий албан тушаалтны залгамж халааны төлөвлөгөө
- 4.2 Хороо нь эрх бүхий албан тушаалтны залгамжлах нэр дэвшигчийг олж тодорхойлно
- 4.3 Нэр дэвшүүлэх хороо нь эрх бүхий албан тушаалтан томилох нэр дэвшигчийг тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага, гаргасан амжилтыг нь нягтлан шалгасны үндсэн дээр тодорхойлно.
- 4.4 Эрх бүхий албан тушаалтан шинээр буюу улираан нэр дэвшигчийг томилох, өөрчлөх саналыг Хорооноос ТУЗ-д гаргана. ТУЗ нь Гүйцэтгэх захиралд санал оруулж болно.
- 4.5 Өндөр насны тэтгэвэрт гарах болон ирээдүйд бий болох сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо нь жил бүр судалгаа хийнэ.

ТАВ. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВАХ
АРГА ХЭМЖЭЭ БУЮУ ТҮР ТОМИЛГОО

- 5.1 Эрх бүхий албан тушаалтан гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн тохиолдолд Хороо яаралтай хуралдаж ТУЗ-д санал оруулж шийдвэрлүүлнэ.
- 5.2 Эрх бүхий албан тушаалтнаас бусад газар, хэлтсийн захирал нь гэнэтийн шалтгааны улмаас чөлөөлөгдөх тохиолдолд орлох ажилтанг Хүний нөөцийн менежер холбогдох Газрын захирал, Гүйцэтгэх захирал нарын бүрэлдэхүүнтэй яаралтай хуралдан компаний дүрэм журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу томилгоог албажуулна.

ЗУРГАА. ХЯНАЛТ

- 6.1 Энэхүү бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хяналт тавин ажиллана.